



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 498

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Хархорин АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон нийт 7 ширхэг 31,425,959.29 /гучин нэгэн сая дөрвөн зуун хорин таван мянга есөн зуун тавин есөн төгрөг хорин есөн мөнгө/ төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Хархорин АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ж.Бадрах нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Акталсан хөрөнгийг худалдсанаас олох орлогыг компанидаа төвлөрүүлэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0000998

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн
...498... дугаар тогтоолын хавсралт

"Хархорин АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй актлах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Бүгд үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Арматур ороогч /1.5м-ийн кольцоны/	2004.06.09	1	876,900.00	876,900.00	876,900.00	0.00
2	Е тогоо	2007.07.25	1	13,636,363.64	13,636,363.64	13,636,363.64	0.00
3	Халаалтын зуух /MB-08 маркийн уур/	2005.09.16	1	9,678,500.00	9,678,500.00	9,678,500.00	0.00
4	Явуулын гагнуурын аппарат	2004.06.06	1	1,304,000.00	1,304,000.00	1,304,000.00	0.00
5	Хэв /1м-ийн кольцоны/	2004.06.18	1	3,174,926.09	3,174,926.09	3,174,926.09	0.00
6	Камер /дигитал канон/	2007.05.07	1	490,095.56	490,095.56	490,095.56	0.00
7	Хэв /1,5м-ийн кольцоны/	2003.06.15	1	2,265,174.00	2,265,174.00	2,265,174.00	0.00
	Нийт дүн		7		/гучин нэгэн сая дөрвөн зуун хорин таван мянга есөн зуун тавин есөн төгрөг хорин есөн мөнгө/	31,425,959.29 /гучин нэгэн сая дөрвөн зуун хорин таван мянга есөн зуун тавин есөн төгрөг хорин есөн мөнгө/	0.00